

Эрх мэдэлтнүүдэд хандсан уриалга хүний эрхийн зөрчлийн хохирогчдод туслаж чадна. Та үзэл санааны хоригдолыг суллаж, эрүүдэн шүүхийг таслан зогсоож чадна. Магадгүй та хэн нэгнийг цаазлагдахаас аварч болох юм. Иймд уриалга бүр чухал...

2008 оны 10 дугаар сар

Хүндэт уншигчдаа

The Wire өөрчлөгдөж байна.

Бидэнд "The Wire"-ын уншигчдадаа хүргэх сэтгэл хөдөлгөм мэдээлэл байна.

Дараагийн дугаар маань таныг гайхшруулах байх.

12 дугаар сараас эхлэн Wire нь хэвлэмэл болон цахим гэсэн хоёр төрлөөр гарах боллоо. Хэвлэмэл сонин бичиг нь жилд 6 удаа гарах бөгөөд кампанит ажил, судалгааны тайлангуудыг нэгтгэн илүү дэлгэрэнгүй мэдээллийг багтаах болно. Харин цахим хувилбар нь манай блогчид таны анхаарлыг татах сэдэвтэй үйл ажиллагаануудыг түргэн хугацаанд цахим хэвлэлд оруулсан байна.

Шинэчлэгдэн гарах The Wire-ийн шинэ загварыг 12 дугаар сарын эхээр хэвлэн нийтлэхийн тулд 10 ба 11 дүгээр сарын гарах хуучин хэвлэлийг бид хойшлуулж байгаа юм.

Хэрэв та The Wire хэвлэлийг захиалахыг хүсвэл маркетингийн багт хандаж болох ба ppmsteam@amnesty.org цахим шуудангаар захиалж болно.

Сайн сайхныг хүсье.

The Wire сонин бичгийн баг



Япон

Цаазаар авахуулах ялтай 40 жил гянданд

түүнийг бусад хоригдлуудтайгаа ярих, зурагт үзэх зэргийг нь хоригложээ.

Цаазаар авах ял сонссон Хакамада Ивао 40 жил хоригдохдоо 28 жилийг ганцаарчилан хориход өнгөрүүлсэн бөгөөд одоо 72 настай, сэтгэцийн өвчтэй түүнийг Хууль зүйн сайд өршөөл үзүүлэх эсхүл дахин шүүх хурал хийлгэх зөвшөөрөл авахгүй юм бол цаазлуулах эрсдэлд ороод байна.

1968 онд шударга бус шүүх хурлын дараа Хакамада ажилладаг үйлдвэрийнхээ гүйцэтгэх захиралыг эхнэр, 2 хүүхдийнх нь аминд хүрсэн хэмээн хэлмэгдсэн юм. Байцаалтын дараах 20 дахь өдөр тэрээр гэм буруутайгаа

хүлээсэн ч энэ үеэр тэр зодуулж байснаа мэдэгдэж байжээ.

Хакамадын өмгөөлөгчийг байцаалтын үеэр түүнтэй уулзахыг хориглож, байцаалтыг өдөрт 12 цагаас илүү хугацаатайгаар үргэлжлүүлдэг байсан байна. Хожим Хакамада нь хэргээ хүлээсэнээ үгүйсгэсэн юм. Шүүх хурал дээр байсан гол нотлох баримтууд нь учир дутагдалтай тухайлбал үйлдвэрээс олсон цустай хувцас нь түүнд хэтэрхий багадааар байсан аж. Өмгөөлөгчийнх нь үзэж байгаагаар Хакамадагийн хэрэглэсэн гэж үзсэн хутга нь үхлийн шарх үүсгэхээргүй жижигхэн байжээ. Түүнээс гадна

түүний мэдүүлэг дээрх хохирогчийн гэрээр орж гарсан гээд байгаа хаалга цоожтой байсан аж.


Анхны шүүх хурлын шүүгчдийн нэг 2007 онд Хакамадаг гэм зэмгүй гэдэгт итгэдэг тухайгаа олон нийтэд зарласаныг эс тооцвол давж заалдах удаа дараагийн өргөдөл болон уриалга нь бүгд амжилтгүй болжээ. Кумамото Норимичи бусад хоёр шүүгчтэйгээ түүнийг буруутай гэх шүүхийн шийдвэр дээр маргалдсан боловч ялагдсан байна.

Хакамада хамгийн урт хугацаагаар Японы гянданд хоригдсон хүмүүсийн нэг бөгөөд

Хакамадаг цаазлахгүй байхыг Японы эрх баригчдад хандан уриалж, шударга бус шүүхийн улмаас яллагдаж байгааг нь мэдэгдэнэ үү!

Японд байгаа цаазаар авахыг нь хойшлуулан хорьж буй бүх хоригдлийн ял шийтгэлийг хөнгөрүүлэхийг уриалж доорхи хаягаар захидал бичнэ үү.

Justice Minister Yasuoka Okiharu 1-1-1
Kasumigaseki Chiyoda-ku To-kyo 100-8977 Japan Fax: +81 3 3592 7088 or +81 3 5511 7200



Турк

Туркэд улс төрийн зүтгэлтнүүд цагдаагийн суманд өртөж байна.

2007 оны 10 дугаар сарын 7-нд хууль ёсны сөрөг хүчний зүүн жигүүрийн сэтгүүл борлуулж байсан улс төрийн идэвхтэнүүдийг шалгасны улмаас маргаан үүссэн байна.

Цагдаагийн ажилтнууд гал нээхэд тэдний маргаан өндөрлөж, тарсан бөгөөд 19 настай Ферат Герцет нуруундаа буудуулжээ.

Цагдаагийн ажилтнууд аргагүй хамгаалалтын улмаас бүү хэрэглэсэн хэмээн мэдүүлээд байгаа юм. Хэргийг шийдвэрлэхдээ сум ойлсон, хүн рүү чиглэж буудаагүй гэсэн

хэдий боловч үүнийг нь нотлох ямар нэгэн шүүхийн баримт байхгүй байгаа юм.

Ферат Герцетийн өмгөөлөгчийн хэлснээр жирийн ийм хэрэгт мөрдөн байцаалт заавал явуулах журамтай байдаг байхад гэмт хэрэг болсон газарт мөрдөн байцаалт хийгээгүй, буудуулахдаа өмсөж байсан цамц болох чухал нотлох баримт цагдаагийн газраас алдагдсан ажээ. Хэдийгээр буудалцаанд оролцсон цагдаагийн ажилтнуудыг тусгайлан нэмэлт байцаалтанд оруулсан ч Ферат Герцет болон цагдаагийн долоон

ажилтан офицерууд бүгдийг хохирогчийн тоонд оруулсан байна. Мөрдөлгийг хүчингүй болгосон тул түүнийг буудсан хүн хуулийн өмнө хариуцлага хүлээхгүй байж болох хэдий ч цагдаагийн ажилтнуудыг хүч хэрэглэсэнтэй холбоотойгоор 2008 оны 12 сарын 24 болох шүүх хуралд дуудаж байна.


Эмнести Интернэшнлд анхны тусламж үзүүлсэн хоёр хүнийг эрэн сурвалжилж байна гэсэн мэдээ хүлээн аваад байна. Одоогоор Ферат Герцетэд 15 жилийн ял төлөвлөөд байгаа бөгөөд эдгээр хүмүүст ч ийм ял

өгч болзошгүй байгааг түүний өмгөөлөгч ЭИ-д мэдээлээд байна.

Туркийн эрх баригчдад хандан Ферат Герцетийн хэргийг шударга шүүхээр шүүх, үр дүнг ил мэдээлэхийг шаардан доорхи хаягаар захидал бичнэ үү.

Bakirkoy Public Prosecutor Rahmi Tan Bakirkoy Cumhuriyet Ba savcisi Bakirkoy Adliye Saray1 34144 Osmaniye Bakirkoy Istanbul Turkey Salutation: Dear Prosecutor

Нигери «Дүүжлэгдэхээ хүлээж буй хүн» тайланг уншина уу



ЭМНЕСТИГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Бид өөрсдөд тулгамдаж буй асуудлаа ярилцаж, хэлэлцэхгүй л бол түүнээс гарах үр дүнтэй аргыг олж чадахгүй, дэмий л бухимдсаар суух болно. Асуудлыг хэлэлцэхээс зайлсхийх, хөндөхөөс айх нь хүний эрхийн хамгаалагчдын арга барил, тактик биш юм. Тиймээс Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас сар бүрийн “Эмнестигийн хэлэлцүүлэг” булан нээж байна. Энэ удаагийнхаа булангаар та бүхэнд “Терроризм ба хүний эрх” сэдвээр ярилцахаар Англид өрнөж буй хэлэлцүүлгийн орчуулгыг бэлтгэн гаргаад байна. Та улс төрчдийн эсрэг тэсрэг байр суурин дундаас өөрийн итгэ үнэмшилээ олоорой.

Ямар нэг “Ариун” зорилго, үйл хэргийн төлөө буруу үйлдлээ зөвтгөн тайлбарладаг хандлага улс төрчид болон хүчний байгууллагынханы дунд ихээхэн ажиглагддаг бөгөөд үүний хамгийн тод жишээ нь Терроризмтой тэмцэх дайн юм. Гүйцэтгэх ажлын нэр барьж хүний эрүүдэн шүүгдэхээс ангид байх тэрхүү туйлын эрх, эрх чөлөөг үгүйсгэх нь хэр зохимжтой вэ?. Та бидэнтэй санал бодлоо хуваалцахыг хүсвэл aimncc@magicnet.mn цахим шуудангаар захидал бичээрэй. Мөн дараагийн дугаарт ямар сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх талаархи саналаа бичиж болно.

Эрх чөлөө аюулгүй байдлын талаар ярихуй

Энэ намар Английн засгийн газар “Терроризмийн эсрэг Билл 2008”-ыг батлахыг зорьж байна. Энэхүү Биллд терроризмийн хэрэгт сэжиглэгдсэн хүнийг урьдчилан хорих төвд хорих хугацааг 42 хоног болгон сунгах тухай тусгасан юм. Энэ оны эхээр нийтийн танхимын гишүүдээс уг санаа зөвхөн 8 хүний санал л авчээ. Гэвч энэ Биллийг Лордуудын болон нийтийн танхим аль

алинд нь хэлэлцэж байгаа бөгөөд парламентийн гишүүд үүнийг эсэргүүцэх боломж хайж байна. Дотоод хэргийн сайд Тони Макналти, парламентийн гишүүн Дэвид Дэвис нар аюулгүй байдал, терроризм, гэмт хэрэг, бодлого боловсруулалтын талаар засгийн газарт асуулга тавьж, 42 хоног хорихыг эсэргүүцэж байгаагаа мэдэгдээд байна.

Тони Макналти:

Терроризмийг эсэргүүцэх үйл ажиллагаандаа бидний өмнөө тавьж буй анхдагч зүйл бол олон нийтийн амгалан байдал, үндэсний аюулгүй байдалыг иргэний эрх чөлөөний асуудлын хамт тавих юм. Бид юуны өмнө хүний эрхийг хүндэтгэх ёстой. Бид алан хядлагаас эмээж буй хүмүүсийг хамгаалах, террорист үйл ажиллагаанд сэжиглэгдэгсдийн эрхийг хүндэтгэх хэрэгтэй. Энэ бол зөвхөн дараа нь бодох хэрэг бус засгийн газрын хандлагын төвд байх гол зарчим юм. Терроризмийн эсрэг явуулж буй үйл ажиллагааны гол хэмжүүр хүний эрх, хувь хүний эрх чөлөөг хамгаалах явдалд суурилах ёстой. Энэ засгийн газрын хамгийн түрүүнд хэрэгжүүлэх нэг гол ажил бол 1998 онд баталсан хүний эрхийн актыг хэрэгжүүлэх явдал. Иймд үндэсний аюулгүй байдалд эрсдэлтэй хувь хүний эрх чөлөөний асуудлыг тэнцвэржүүлэх хэрэгтэй байна. Бид урьдчилан хорих төвд хорих хугацааг сунгах нь олон нийтийг террорист халдлагаас хамгаалж буй хэрэг гэж ойлгодог. 2007 он гарснаас хойш манай шүүх байгууллагуудад 65 хүн террорист гэмт хэрэгт буруутгагдан хоригдож байна. Мөн аюулгүйн алба, агентлагуудад 200 орчим бүлэг 2000 орчим хүмүүс бүртгэгдсэн байна. Заналхийлэл бол бидний өмнө нь туулж байснаас илүү харгис хэрцгий зүйл билээ.

Заналхийлэл бол хэмжээ мөн чанараараа урьдчилан таагдах аргагүй. Ихэнх нь эвдлэн сүйтгэхэд чиглэж амиа золиослон бөмбөг дэлбэлж байна. Террорист хуйвалдааныг зохион байгуулагчид гадаадын олон янз бүрийн хүмүүстэй сүлбэлддэг. Энэ нь мөрдөн шалгагчдын хувьд технологийн болон логикийн маш өндөр сорилтыг бий болгож байна.

Терроризмын эсрэг Билл 2008 нь олон нийтийн прокурорын газрын дэмжлэгтэйгээр тодорхой нөхцөлд хэрэглэх хүч, эрх мэдлийн талаар юм.

Энэ нь нийтийн болон Лордын танхим 2 хүчингүй болохоос өмнө буюу 30 хоногийн дотор бүгд хүлээн авсан тохиолдолд хэрэгжих юм.

Парламент зөвхөн эрх мэдлийн эхлэлийг тавихад санал өгөхөөс бус хуулийн хүрээнд шүүхэд өгөгдсөн асуудалд анхаарлаа хандуулахгүй. Хувь хүнийг хорих тухай шийдвэрийг шүүгч л гаргана.

Тэд сэжигтэн хуулийн дагуу буруутгагдсан үед тус хэрэгт оролцох бөгөөд хорих өдрийг 7 хоногоор л сунгаж болно.

Бидний мөрөөдөж буй зүйл бол хүмүүсийг аль болох хурднаар хэргийг нь шийдвэрлэх. Өмнө нь бид ийм бодлого барьж байсан. Ирээдүйд ч бас ийм бодлого барих болно. Эрх баригчид хэрэг хүлээлгэх явдлыг сааруулж байна гэдэг бол ташаа зүйл бас үнэнд нийцэхгүй. Энэ нь засгийн газрын бодлогыг үл зөвшөөрсөн хэрэн. Гэвч энэ иргэний эрх чөлөө

хүний эрхийн асуудлын талаархи бидний хандлагыг хэт дөвийлгэх нь тохиромжтой бус бөгөөд бидний дайсныг өөгшүүнэ. Терроризм бол иргэний эрх чөлөө, ардчилалд харш зүйл. Бид өөрсдийгөө аюулгүй байна хэмээн тайвшруулж болохгүй бөгөөд энэ бүхэн террорист хандлагаас ангид байх Британичуудын эрх чөлөөнд халдсан хэрэг болно.

Дэвид Дэвис

Урьдчилан хорих байранд 42 хоног хорих явдлыг эсэргүүцэж байгаа нь миний хувьд зарчмын зүйл. Би өөрийн бодлыг хэлэлцүүлгийн үед тодорхой хэлсэн. Гэвч энэ намар терроризмын эсрэг Биллийг дахин авч үзэх болсон. Би энэхүү Биллийг зөвшөөрч буй хүмүүс дахин нэг үншаасай гэж хүсэж байна. Хэрэв Билл хэвээр батлагдвал Англи улс манай нийгмийн гол ноён нуруу болсон иргэний эрхээс татгалзаж, терроризмын эсрэг тэмцэх хүч сулрах болно. Энэ нь эмх цэгцгүй, хууль суларч буй хэрэг болно. Шинэ хууль нь 100 жил үйлчилж ирсэн Магна Картын (баривчлах үндэслэлийн талаар) зарчмыг дорд үзэж буй хэрэг юм. Урьдчилан хорих хугацааг сунгах нь бидний суурь эрхийн нэгийг зөрчиж буй хэрэг билээ.

Баривчлагдсан хэн боловч шударга шүүхээр богино хугацаанд шүүгдэх, эсвэл суллагдах ёстой. Англи улсад 28 хоног урьдчилан хорих тухай Терроризмийн эсрэг хууль бий. Энэ нь хуулийн хүрээнд

авч үзвэл бусад улсуудтай харьцуулахад хамгийн урт хугацаа юм. Бид мөн Их Британийн дэлхийд эзэлдэг байр суурийг бодолцох хэрэгтэй. Бусад улс Британид юу болж байгааг анхаардаг. Тэд биднийг дагахыг эрмэлздэг. Цаашид Англи улс бусад оронд хүний эрхийг шүүмжилэхэд бид бэрхшээлтэй тулгарах болно. Учир нь бид бас хүний эрхийг зөрчиж байна. Бодит амьдрал дээр 42 хоног урьдчилан хорих нь нийгмийн харилцаа ялангуяа Англи дахь Муслим хүмүүст ихээр нөлөөлөх болно. Үүнийг бид 30 жилийн өмнөх хойд Ирландын түршлагаас харах ёстой. Терроризмийн эсрэг Билл бол мөн ижил нөлөө үзүүлж болох бөгөөд биднийг алдаанд хүргэж магадгүй юм. Энэ Билл хүчирхийллийг зогсоож чадахгүй. Хойд Ирландад католик шашинтнуудын эрхийг зөрчиж байсан шиг асуудал Англид давтагдах бөгөөд эрх баригчдад дайсагнах явдал ихсэх болно. Энэ нь хүмүүст шүүхийн өмнө өөрсдийгөө хамгаалах боломж өгч буй хэрэгтэй адилгүй билээ.

Хаяг: Сүхбаатар дүүрэг,
6-р хороо,
Бага тойруу - 44, 10 тоот
Утас/факс: 976-11-324705
И-мэйл: aimncc@magicnet.mn
www.amnesty.mn

